

**ÄÄÐ×ÈÄ**

1. Äàððàí ñòì ùí ÈÒÕ-ùí àí ðäóääàð ðóðàèääàí 2 - 6
2. Äàððàí ñòì ùí ÈÒÕ-ùí ýýèæè òì , ðäóääàð ðóðàèääàí 7-23
3. Äàððàí ñòì ùí ÈÒÕ-ын Òýðãçèýã-дийн хуралдаан 24-27
4. Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс хэрэгжүүлсэн ажлууд 28-37
5. Дархан сумын ИТХ, Тэргүүлэгчдээс 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Дархан сумын ГХУСА33-ын 2017 оны ажлын төлөвлөгөө 38-48

ÄÄÐÕÁÍ ÑÕÌ ÛÍ ÈÕÕ-ÛÍ 7 ÄÄÕÛ ÓÄÄÄÆËÍ  
ÑÌ Í ÁÓÕËËÍ ÁÍ ÕÄÓÄÄÐ ÕÓÐÄËÄÄÍ  
ÕÓÐÄËÄËÄ

Ääðõáí-Óöë àéì æéí Ääðõáí ñõì ÛÍ ÈÕÕ-ÛÍ 7 ääõÛ óäääæëí ñì í æóëëéí  
анхдугаар дордгээд 2016 ий 11 айгээд ñäðÛÍ 07-í Û °ä°ð ñõì ÛÍ ðõäëääàí Û  
танхимд болов.

Áí õäóäääð ðõäëääàí Ûä ñõì ÛÍ ÈÕÕ-ÛÍ насаар ðàì æéí àõì ää ð°è°è°ä-  
Ж.Балжинням ääðääëä. Õõäëääàí ä ирвэл зохих 31 ð°è°è°ä-æөс 30 Төлөөлөгч  
ирж, 96,7 дордгээтэй эхлэв.



Áí õäóäääð ðõäëääàí ääð:

1. Ääðõáí ñõì ÛÍ ÈÕÕ-ÛÍ äñì í ä ð 7 дахь удаагийн ñì í æóëëéí äçì , Ò°è°è°ä-æëéí äçäýí ýððëëäç° äð°ð° ðõäë
2. Çì õèí í ääëæóëäëðÛÍ äñóääë
  - Ääðõáí ñõì ÛÍ ÈÕÕ-ÛÍ ääðäÛ äñì í ä ж батлах тухай
  - Ääðõáí ñõì ÛÍ ÈÕÕ-ÛÍ Õýðäççëýä-äëëäñì í ä ж батлах тухай
  - Ääðõáí ñõì ÛÍ Çàñäãääðäää í ýð äýäð ççëýð ðõäë

äñóääëóóäÛ äðõñ ðõñ ðýëýëðëýý.

Õõäëääàí ääñ Ääðõáí ñõì ÛÍ ÈÕÕ-ÛÍ сонгох ñì í æóëëéí äçì äýýð Ääðõáí  
ñõì ÛÍ ÈÕÕ-ÛÍ Ò°è°è°ä-æ°ð ñì í ä ääñì í 31 Т°è°è°ä-æëéí äçäýí ýððëëäç° äð°ð°ç,  
баталгаажуулав. Төлөөлөгчдөд энгэрийн тэмдэг, үнэмлэхийг гардуулав.



Ääðõáí ñõì ÛÍ ÈÕÕ-ÛÍ ääðäää Æ.Áäëæëí í ýì ын í ýððëëä äýäð ççëæ ðõäëääàí ä  
í ðì èõñì í Т°è°è°ä-æëéí 100 дордгээтэй ñàí äëаар Ääðõáí ñõì ÛÍ ÈÕÕ-ÛÍ ääðäääð  
ñì í ä ääлоо.



Áí óäóäääð óððäëääáí ä î ðí ëöñí í ò° è° è° ä-äëéí 100%-ëéí ñáí àëääð Äàððáí ñòí ùí Çàñàä äàðäää Б.Азжаргалын í ýðëéä äýâ ÿçæ àéí æéí Çàñàä äàðäää óëàì æàðääð ø èëäýðëýлээ.

Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд 10 Төлөөлөгч нэр дэвшиж, олонхийн саналаар

Õðëëúí äàðää Æàì úýí ñçðýí гийн Áàëæéí í ýì

Õðäççëýä-ëä Намсрайн Болор-Эрдэнэ

Биньегийн Лхагвасүрэн

Дарьсүрэнгийн Жамбалдорж

Равдандоржийн Урангуа

Тэгшжавын Чимгээ

Зоригтын Эрдэнэбат

нар соногдлоо.



ÄÄÐÏÄÍ ÑÒÌ ÙÍ ÈÏÏ-ÛÍ Õ Æªª Æª Æª Æª

1	Ò° è° è° ä-äëéí î áî ä í ýð	Õí éðæéí äóäääð	Àæëë, àëääí óòø ààë
1	Баяр Даваасамбуу		“Өгөөж чанар” ХХК-ийн ерөнхий захиарл 99115967
2	Бавал Бадамханд		Дархан сумын 2 дугаар багийн Засаг дарга 99279707
3	Бинье Лхагвасүрэн		Дархан дулааны сүлжээ ХК-ийн Хяналтын хэлтсийн дарга 99032718

## МЭДЭЭЛЭЛ

4	Дорж Туяа		3	Дархан сумын 3 дугаар багийн Засаг дарга 99399361
5	Намсрай Болор-Эрдэнэ			УБТЗ-ын татах хэсэг, хэлтсийн дарга 99379922
6	Дарьсүрэн Жамбалдорж		4	Дархан –Уул аймгийн Музейн захирал 95378215
7	Банзар Оюунчимэг		5	Дархан сумын 5 дугаар багийн Засаг дарга 99913416
8	Жамъянсүрэн Балжинням			Дархан сумын ИТХ-ын дарга 99029230
9	Равдандорж Урангуа		6	Дархан сумын 6 дугаар багийн Засаг дарга 99857598
10	Баянбилэг Баясгалан			“Өсөх бүрд” ХХК-ийн захирал 99018521
11	Балжинням Төгөлдөр		7	Дархан сумын Ахмадын хорооны зохион байгуулагч 99394481
12	Ядамбаяр Бат-Очир			Дархан ШУТИС-ын багш 99404017

## МЭДЭЭЛЭЛ

13	Хишгээ Тулгаа			Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч 99081966
14	Зоригт Эрдэнэбат		8	Дархан Ус суваг ХК-ийн Хангамжийн менежер 99378038
15	Билэгсайхан Баасанжав			Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний эмч 99192206
16	Баярдалай Ууганбаяр			ДДЦС ТӨХК-ийн Турбины цехийн ахлах машинист 99063254
17	Мягмар Батбаяр		9	ЭБО сервис ХХК-ийн ижнелер 99040026
18	Вандансүрэн Бат-Эрдэнэ			“Шар нуруу” ХХК-ийн хуулийн зөвлөх 99075132
19	Даваасүрэн Жаргалсүрэн		10	Чингис хаан банкны ерөнхий нябо 99084270
20	Пүрэвсүрэн Ихбаяр			Үндэсний хөрөнгө оруулалтын банкны захирал 99032089
21	Суурь Мөнхзул		11	Номын ундраа дэлгүүрийн захирал 99370863

## МЭДЭЭЛЭЛ

22	Александр Соронзонболд		12	Юнител групп Байгууллага хариуцсан мэргэжилтэн 89110247
23	Бат-Өлзий Нямбаяр		13	Дархан сумын 13 дугаар багийн Засаг дарга 95376034
24	Эрдэнэбат Цогзолмаа		14	Дархан сумын 14 дүгээр багийн Засаг дарга 99053307
25	Чойбат Баттулга		15	“Таван богд” ХХК-ийн салбарын эрхлэгч 99067756
26	Гандорж Батчимэг			Би монгол салоны захирал 99129873
27	Гончигдорж Мөнхцэцэг			Монре даатгалын Дархан дахь салбарын эрхлэгч 94090760
28	Батчулуун Ганзориг		16	ДДЦС ТӨХК-ийн Автомеханикч ижнелер 99014463
29	Тэгшжав Чимгээ			Дархан сумын 16 дугаар багийн Засаг дарга 99377178
30	Ганболд Гантулга		Өргөө	Дархан сумын МАН-ын хорооны улс төрийн ажилтан 88088400

## МЭДЭЭЛЭЛ

31	Эрдэнэдалай Дэмбэрэлсамбуу		Малчин	“Мэнд галт” ХХК-ийн ерөнхий захирал 99372220
----	-------------------------------	---	--------	--

### ААДӨАГ НӨИ ҮГ ҮЕӨ-ҮГ 7 ААДӨ ААААЭЭГ НГ ҮГ ҮЕӨЭЭГ ҮГ ҮЕӨЭӨ 2 АОАААД ОӨДӨЭЭААГ ОӨДӨЭЭЭАА

Ааддөаг нөи үг Үеө-үг 7 аадү оаааэеи нг үг Үеөэеи үг Үеөөд хоёрдугаар оодөэаааг 2016 и г 12 аоааад нэдүг 12-г ү ° ä ð Ааддөаг нөи үг хуралдааны дөг өеи ä боллоо.



Оодөэаааг аад:

- Дархан сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдээс хэрэгжүүлсэн ажлын тайлан
- Дархан сумын ИТХ, Тэргүүлэгчдийн 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг батлах тухай
- Дархан сумын ИТХ-ын дэргэдэх Хороодын бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай
- Дархан сумын 2016 оны батлагдсан төсөвт тодотгол хийх тухай
- Аймгийн Аудитын газраас 2016 оны төсвийн тодотгол, 2017 оны төсвийн төсөлд өгөх саналын тухай
- Сумын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтын биелэлт, үйл ажиллагааны товч тайлан
- Сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх зорилт, төсвийн төслийн тухай
- Дархан сумын Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай

аһооаеөооау а дүеүеөүæø еэааүдөүлээ.

**ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН**

**СУМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХОРОО**

1. **Я.БАТ-ОЧИР**-ДАРГА
2. Б.БАДАМХАНД
3. Т.ЧИМГЭЭ
4. Н.БОЛОР-ЭРДЭНЭ
5. Ч.БАТТУЛГА
6. Б.БААСАНЖАВ
7. Д.ЖАРГАЛСҮРЭН
8. В.БАТ-ЭРДЭНЭ
9. Ж.БАЛЖИННЯМ

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХОРОО**

1. **С.МӨНХЗУЛ** - ДАРГА
2. Д.ЖАМБАЛДОРЖ
3. Б.ОЮУНЧИМЭГ
4. Х.ТУЛГАА
5. Г.БАТЧИМЭГ
6. Г.ГАНТУЛГА
7. Б.ЛХАГВАСҮРЭН

**ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН  
ХОРОО**

1. **Б.ДАВААСАМБУУ** - ДАРГА
2. Э.ДЭМБЭРЭЛСАМБУУ
3. З.ЭРДЭНЭБАТ
4. Д.ТУЯА
5. Б.БАЯСГАЛАН
6. М.БАТБАЯР
7. Э.ЦОГЗОЛМАА

**ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ӨРГӨДЛИЙН ХОРОО -3**

1. **Р.УРАНГУА**- ДАРГА
2. Б.ГАНЗОРИГ
3. Б.НЯМБАЯР

**ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ХОРОО-5**

1. **П.ИХБАЯР** - ДАРГА
2. Г.МӨНХЦЭЦЭГ
3. Б.УУГАНБАЯР
4. Б.ТӨГӨЛДӨР
5. А.СОРОНЗОНБОЛД



## **ДАРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХОРООДЫН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Сумын Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Хороод нь хариуцсан ажлын чиглэлүүдээ Монгол Улсын Засгийн Газар, аймаг, сумын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулахын хамт хэрэгжүүлэх ажлыг жил бүрийн сум, багийн Засаг дарга нарын төлөвлөгөөнд тусгуулан, түүнд хяналт тавьж ажиллахад энэхүү журмын зорилго оршино.

1. Хороо бүр хариуцсан ажлын хүрээнд асуудал нэг бүрт тодорхой зорилт дэвшүүлэх, түүндээ хүрэх, уг ажлыг сайжруулах, хууль тогтоомжид заагдсан хэмжээнд байлгах талаар бүрэн эрхийн хугацаанд жил, улирал тутам төлөвлөж, сумын Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын даргаар батлуулан хэрэгжүүлж, гүйцэтгэлийг нь дараа улирлын эхний 10 хоногт багтаан Тэргүүлэгчдэд танилцуулж, тайлангаа бичгээр ирүүлнэ.
2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар, шаардлагатай гэж үзвэл Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлуудыг урьдчилан судалж, Хороон дээрээ хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт гарган, шийдвэрт тусгах оновчтой санал боловсруулан оролцоно.
3. Хууль тогтоомжуудад тусгагдсан Хурал, Тэргүүлэгчид, Төлөөлөгчийн бүрэн эрхийг сайтар судалж, түүний хэрэгжилтэнд хяналт тавина.
4. Хууль тогтоомж, хуралдааны шийдвэрийг тойргийнхоо сонгогчдод хүргэж сурталчлах, биелэлтийг хянаж шалгах, тайлан мэдээ гаргах ажлын өгөгдсөн удирдамж, үүргийн дагуу хугацаанд нь гүйцэтгэнэ.
5. Хариуцсан ажлын чиглэлээрээ багийн Иргэдийн Нийтийн Хурал, сумын Засаг даргын Тамгын газар, аж ахуй нэгж байгууллагууд, албан тушаалтнуудын үйл ажиллагаатай танилцах, үзлэг шалгалт хийх, мэдээ тайланг сонсох, шаардлагатай бол удирдамж боловсруулан, Хурлын даргаар батлуулан ажиллаж, зөвлөгөө, үүрэг даалгавар өгөх, албан шаардлага тавьж, биелэлтийг хангуулах, зарим тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх, хариуцлага тооцуулах арга хэмжээ авч болно.
6. Хороод үйл ажиллагаандаа иргэд, сонгогчид, уг ажлыг хариуцан гүйцэтгэх болон хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнуудыг аль болох өргөнөөр татан оролцуулна.

7. Хариуцсан ажлын хүрээнд багтах асуудал бүрт байнгын судалгаа дүгнэлттэй байж, зайлшгүй шийдвэрлэх, зохицуулах шаардлагатай асуудал байгааг тухай бүр нь мэдээлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллана.
8. Хороо бүр улирал тутам үйл ажиллагаагаа нэгтгэн явуулдаг тогтсон өдөртэй байна.
9. Хороодын эрхлэх асуудал

### **Нэг. Сумын хөгжлийн бодлогын хороо**

- Өмч, төсөв, төлөвлөгөө
- НӨУБ-ыг бэхжүүлэх, төлөвшүүлэх, төлөөлөгчидтэй ажиллах
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа
- Орон нутгийн өмчийн удирдлага зохицуулалт, ашиглалт хамгаалалт
- Орон нутгийн төсөв, түүний гүйцэтгэл, хяналт
- Санхүүгийн чадавхийг дээшлүүлэх
- Статистикийн мэдээ, мэдээлэл
- Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар

### **Хоёр. Хүний хөгжил, нийгмийн бодлогын хороо**

- Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх
- СӨБ, ЕБС, МСҮТ, Их дээд сургуулийн оюутан сурагч
- Зорилтот бүлэгт чиглэсэн бодлого
- Боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан
- Хүн амын эрүүл мэнд, нийтийн биеийн тамирын бодлого
- Монгол хэл бичиг, үндэсний уламжлал, ёс заншлын талаар баримтлах бодлого
- Сүм хийд, шашны байгууллагуудтай харилцах
- Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудтай харилцах

### **Гурав. Үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээ, байгаль орчин, хот байгуулалтын хороо**

- Бүсчилсэн хөгжил
- Барилга, хот байгуулалт, газрын кадастр, бүртгэл
- Газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, байгалийн бусад баялаг
- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар
- Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн бодлого
- Хүнсний аюулгүй байдлыг хангах

- Мал аж ахуй, малын даатгал, удмын сан, эрүүл мэндийг хамгаалах бодлого
- Газар тариаланг эрчимжүүлэх бодлого
- Ус, агаар, хөрсний бохирдлыг бууруулах
- Усны бодлого, нөөцийн аюулгүй байдал
- Хог хаягдал, дахин боловсруулалт
- Ашигт малтмал, геологи, уул уурхайн холбогдолтой бодлого, эрэл хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлд тавих хяналт
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих бодлого
- Түлш, эрчим хүч, зам тээвэр, шуудан, харилцаа холбоо
- Орон сууц, нийтийн аж ахуй, СӨХ
- Үйлдвэрлэл, үйлчилгээний техник, технологийн хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого

### **Дөрөв. Хууль эрх зүй, өргөдлийн хороо**

- Эрх зүйн бодлого, туслалцаа
- Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх түүний явцад хяналт тавих
- Иргэний танхим
- Хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
- Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого
- Сумын Хурлын шийдвэрийн хэрэгжилт, хяналт, шалгалт
- Олон нийтийн санал асуулга
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх
- Архи, тамхи, мансууруулах бодисыг хязгаарлах, хэрэглээг таслан зогсоох
- Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах бодлого
- Гамшгаас хамгаалах бодлого

### **Тав. Төсөл хөтөлбөр, гадаад харилцааны бодлогын хороо**

- Хурлын гадаад харилцаа
- Төрөөс олгож буй зээл, тусламж, сангийн олголтод хяналт тавих
- Гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн бодлого
- Сумын хөгжлийн хандлагыг тодорхойлох, үндсэн чиглэл, хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт

### ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2017-2020 ОНД БАРИМТЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Иргэд, аж ахуйн нэгж байгууллага, хамт олны бүтээлч санаачлага, идэвхтэй оролцоонд тулгуурлан ажиллах зарчмыг баримталж, иргэдийн эрх ашиг, орон нутгийн хөгжлийн асуудлыг тэргүүн эгнээнд тавьж, хүний хөгжлийг бүх талаар хангах, нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлж, чадавхийг нь дээшлүүлэх, хууль ёсыг хэлбэрэлтгүй сахин биелүүлэхэд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн зорилго оршино.

#### **Нэг. Сумын хөгжлийн бодлогын чиглэлээр**

Сумын төсөв санхүү, татварын бодлого, өмчийн харилцааг оновчтой тодорхойлж, сум, орон нутгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

1.1 “Дархан 2022” хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтэнд хяналт тавих

1.2 Орон нутгийн төсвийн тогтвортой, бие даасан байдлыг бэхжүүлж, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхэд дотоод болон гадаад эх үүсвэрүүдийн таатай боломжуудыг бүрэн дүүрэн ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх бодлого баримтлах

1.3 Сум, орон нутгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын оролцоо, хөрөнгө оруулалтыг хандуулах

1.4 Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангах, үр ашгийг дээшлүүлэх талаар сумын ИТХ-аас тавих хяналт, шаардлагыг өндөржүүлэх

1.5 Татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулах, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас тогтоодог татвар, төлбөр, хураамжийг орон нутгийн онцлогт тохируулан шинэчлэх зэрэг орлогын шинэ эх үүсвэр бий болгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, сумын төсвийн орлогын бүрдэлтийг сайжруулах бодлого баримтлах

1.6 Шинжлэх ухааны ололт, шинэ техник технологи, мэдээллийн технологи, инновацийн хөгжлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн хөгжүүлэх, нутагшуулах замаар нэмүү өртөг шингэсэн, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийг дэмжих

1.7 Орон нутгийнхаа өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл, хяналт, зарцуулалтыг сайжруулан, үр ашгийг дээшлүүлэх бодлого барьж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт тавих

1.8 Статистик мэдээ мэдээллийн үнэн зөв, ил тод, хараат бус бие даасан зарчмыг хангаж, гарсан мэдээ мэдээлэлд тулгуурлан, сумын төсөв, хөгжлийн бодлогоо тодорхойлох

## **Хоёр. Хүний хөгжил, нийгмийн бодлогын талаар**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллыг сайжруулж, боловсрол, соёл, эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг хөгжүүлснээр хүний хөгжлийн индексийг улсын дундаж түвшинд хүргэхэд чиглэгдэнэ.

2.1. Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид, баялаг бүтээгчдийг дэмжих, Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг идэвхижүүлэх замаар иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх

2.2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүртээмж, хамрагдалтыг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын анги, сургууль завсардалтыг бууруулах, сурагч, хүүхэд багачуудын сурч, хүмүүжих, хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэх

2.3. Орон гэргүй, бүртгэлгүй иргэдийг нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлүүлэх

2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх

2.5. Орон сууцны хорооллыг нийгэм, ахуйн барилга, байгууламжуудын хамт төлөвлөж, байгуулах

2.6. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх дадал зуршлыг олгох сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах

2.7 Иргэдийн уламжлалт зан заншил, ардын язгуур урлаг, гар урлалыг үр хойчдоо өвлүүлэх, сургах үйл ажиллагааг дэмжих

2.8 Урлаг, уран сайхан, спортын төрлүүд, нийтийн биеийн тамираар хичээллэх иргэдийн санал санаачлагыг дэмжих

2.9 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих

2.10 Иргэдийн нөхөрлөл хоршоо, сонирхол, хуримтлалын бүлэг, хөршийн холбооны үйл ажиллагааг боловсронгуй болгож, багаар хоршиж ажиллах нөхцлийг бүрдүүлэх, дэмжих

### **Гурав. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, байгаль орчин, хот байгуулалтын хороо**

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг эдийн засгийн үндэс суурь болгон хөгжүүлэх, хот төлөвлөлт, хот байгуулалт, барилгажилт, тохижилт, газар зохион байгуулалтыг хотын нэгдсэн төлөвлөгөөний дагуу явуулж, байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.

3.1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн үйлдвэрлэл-технологийн паркийн үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, фермерийн болон эрчимжсэн хөдөө аж ахуйн газар тариаланг дэмжих бодлого баримтлах

3.2. Сумын хэмжээнд байгалийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг арилгах, нөхөн сэргээх чадварыг нэмэгдүүлэх

3.3. Сумын агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, Дархан хотыг “Эрүүл хот” болгох

3.4. Үерийн далан суваг, борооны ус зайлуулах шугамыг сэргээн засварлах, хотын ногоон бүсийг хамгаалалтанд авах, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх зэрэг хотын тохижилтонд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

3.5. Хараа голын сав газар, хот орчмын ногоон бүсийн эдэлбэр газрыг ашиглуулах, эзэмшүүлэхэд хяналт тавих

3.6. Газрын бүсчлэл, үнэлгээний системийг боловсронгуй болгон газрын харилцааны чиглэлээр үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, газар олгох, эзэмшүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих

3.7. Хотын хөгжил, дахин төлөвлөлт, тохилог хороолол, жишиг гудамж, инженерийн шугам сүлжээ иргэдийн санал санаачлагад тулгуурлах бодлого явуулах

3.8. Сууц өмчлөгчдийн холбоодын иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулж, гэр хорооллын ус түгээх худгуудыг цэвэр усны нэгдсэн шугамд холбох ажлыг гадаадын зээл тусламжаар гүйцэтгүүлэх ажлыг үргэлжлүүлэх

3.9. Зорчигч тээврийн үйлчилгээг найдвартай, шуурхай, чирэгдэлгүй байлгахад чиглэсэн бодлого баримтлах

3.10. Хорооллын дундах авто зам, автомашины зогсоолыг өргөтгөх, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолыг шаардлагатай газруудад шинээр байгуулах, замын тэмдэг, тэмдэглэгээг шинэчлэх зэрэг ажлыг хэрэгжүүлж, хяналт тавих

3.11 Хотын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох бодлого баримтлах

3.12. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлогыг баримтална.

### **Дөрөв. Хууль эрх зүй, өргөдөл гомдлын чиглэлээр**

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, төр иргэний уялдаа холбоог сайжруулна.

4.1. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, төсөв, татвар, газар, ус, эрүүл мэнд, байгаль хамгаалах, зэрэг хуулиудад орон нутгийн болон иргэдийн амьдрал, эрх ашгаас урган гарсан саналуудыг тусгуулах ажлыг байнга анхаарч ажиллах

4.2. Сум, орон нутгийн өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд иргэдийн санал бодлыг авч, шийдвэрийн төсөлд тусгах, иргэдийн болон хөндлөнгийн хяналтын механизмыг нийгмийн харилцааны өнөөгийн байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх орчинг бүрдүүлэх

4.3. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж шуурхай байдлыг дээшлүүлж, хүнд суртал, чирэгдэл гаргахгүй байхад төрийн албан хаагчдын үйл ажиллагааг чиглүүлж, иргэдийн санал хүсэлтийг барагдуулж, эргэж мэдээлэх тогтолцоог улам боловсронгуй болгох

4.4. Иргэдийн амгалан тайван ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, архидан согтуурах явдлыг бууруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, хууль сахиулах болон иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн санал санаачлага, оролцоо, хамтын ажиллагааг идэвхжүүлэх

4.5. Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэж, орон нутгийн төрийн албан хаагчдыг авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, урьдчилан сэргийлэх

4.6. Төрийн архив, албан хэрэг хөтлөлт, архивын баримтын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах

4.7. Иргэн, багийн захиргаа, ИТХ-ын Төлөөлөгчийн гурвалсан холбоо, хамтын ажиллагаа, уялдааг сайжруулах зорилгоор нээлттэй утас, саналын хайрцаг тогтмол ажиллуулж иргэдээс ирсэн санал хүсэлт, гомдол санаачлагыг богино хугацаанд шийдвэрлүүлж хариу мэдээллэх тогтолцоог бүрдүүлж ажиллах

4.8 Дархан сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах

4.9 Дархан сумын ИТХ-ын хуралдаанаас гаргасан Төлөөлөгчдийн санал, хүсэлтийн хэрэгжилтэнд хяналт тавих, бусад Хороодуудтай хамтран ажиллах

4.10 Дархан сумын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулахад олон улсын туршлагыг судалж нэвтрүүлэх

### **Тав. Төсөл хөтөлбөр, гадаад харилцааны бодлогын байнгын хороо**

Төсвийн ил тод байдлыг хангаж, орон нутгийн эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

5.1. Сумын хөгжлийг ахиулахад гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх

5.2. Аймаг, хот, сумдын ИТХ-ын хамтын ажиллагааг өргөжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавхийг дээшлүүлэх чиглэлээр туршлага солилцох, хамтран ажиллах

5.3. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сангаас олгогдож буй зээлийн олголт, хуваарилалт нь санхүүгийн дэмжлэг шаардлагатай иргэд, баялаг бүтээгч аж ахуй нэгж, байгууллагуудад хүрч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах

5.4. Олон улсын болон төслийн байгууллагуудаас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг дэмжих

5.5. Хөдөлмөр, нийгмийн халамжийн байгууллагаас олгодог зээл тусламжинд хяналт тавих, хамтран ажиллах

ДАРХАН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН  
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 02/06

Дархан

**Сумын 2017 оны төсөв  
батлах тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.1.”к”, 18.1.2.”а”, “б”, 25 дугаар зүйлийн 25.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 61-дүгээр зүйлийн 61.4, 64-дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, 2016 оны 05/02-агшаа 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит 5 дугаар хуралдааны 2016 оны 05/02-агшаа 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит 2 дугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:

Төсвийн 2017 оны төсөвт төвлөрүүлэх нэр төрөл, өмнөх тусгай зориулалтын өөрийн орлого (мянган төгрөг)

Д/д	Орлогын нэр төрөл	Дүн
<b>1.1.</b>	<b>Сумын төсвийн татварын орлого</b>	<b>1730093.2</b>
1.1.1	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний үйл ажиллагааны орлогын албан татвар	384493.2
1.1.2	Хөрөнгө борлуулсаны орлогын албан татвар	347000.0
1.1.3	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	353000.0
1.1.4	Бууны албан татвар	26600.0
1.1.5	Улсын тэмдэгтийн хураамж	80000.0
1.1.6	Түгээмэл тархацтай АМАТ	1,000.0
1.1.7	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	146000.0
1.1.8	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	392000.0
<b>1.2</b>	<b>Сумын төсвийн татварын бус орлого</b>	<b>396526,1</b>
1.2.1	Сум хөгжлийн сангийн орлого	396526,1
<b>1.3.</b>	<b>Өөрийн төлбөрийн орлого</b>	<b>23861578,3</b>
1.3.1	Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигдэх байгууллагуудын өөрийн орлого	68300,0
1.3.2	Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигдэх байгууллагуудын өөрийн орлого	23732977,7
1.3.3	Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигдэх байгууллагуудын өөрийн орлого	60300,6
	<b>Нийт дүн</b>	<b>25988197,6</b>



## МЭДЭЭЛЭЛ

**Хоёр.** Дархан сумын 2017 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

Д/д	ТЕЗ, түүний харьяа байгууллага	Дүн
<b>2.1.</b>	<b>Засаг дарга</b>	<b>60300,6</b>
<b>2.1.1</b>	<b>Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигдэх байгууллагуудын өөрийн орлого</b>	<b>60300,6</b>
2.1.1.1	1-р сургууль	1127,0
2.1.1.2	4-р сургууль	1023,0
2.1.1.3	Од цогцолбор	1969,5
2.1.1.4	ОИЦогцолбор	40064,6
2.1.1.5	9-р сургууль	3635,3
2.1.1.6	15-р сургууль	2954,3
2.1.1.7	Жигүүр цогцолбор	2461,9
2.1.1.8	18-р сургууль	2158,9
2.1.1.9	Музей	3,000.0
2.1.1.10	Номын сан	48,9
2.1.1.11	Хүүхдийн номын ордон	1857,2

**Гурав.** Сумын 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурьдсан төсөв зарцуулах эрх олгосугай.

(мянган төгрөг)

Д/д	ТЕЗ, түүний харьяа байгууллага	Дүн
<b>3.1.</b>	<b>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга</b>	<b>124852,5</b>
	Урсгал зардал	124852,5
<b>3.1.1</b>	<b>ИТХ-ын ажлын алба</b>	<b>124852,5</b>
	Урсгал зардал	124852,5
<b>3.2.</b>	<b>Засаг дарга</b>	<b>25285786</b>
	Урсгал зардал	<b>25217486</b>
<b>3.2.1</b>	<b>Сумын ЗДТГазар</b>	<b>979181,6</b>
	Урсгал зардал	979181,6
<b>3.2.2</b>	<b>Орон нутгийн нөөц хөрөнгө</b>	<b>48500,0</b>
	Урсгал зардал	48500,0
<b>3.2.3</b>	<b>Сум хөгжүүлэх сан</b>	<b>396526,1</b>
	Урсгал зардал	396526,1
<b>3.2.4</b>	<b>Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигдэх байгууллагуудын урсгал зардал</b>	<b>23793278,3</b>
	Урсгал зардал	23793278,3
	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>68300,0</b>
<b>3.2.5</b>	<b>Сумын орон нутгийн хөгжлийн сан</b>	<b>68300,0</b>
	Хөрөнгийн зардал	68300,0
	<b>Нийт дүн</b>	<b>25410638,5</b>

## МЭДЭЭЛЭЛ

**Дөрөв.** Сумын төсвөөс 2017 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг **25988197,6** мянган төгрөгөөр баталсугай.

**Тав.** Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг **577559,1** мянган төгрөгөөр баталсугай.

**Зургаа.** Сум төсвөөс 2017 оны төсвийн жилд төсвийн шууд захирагчдад олгох Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

Д /д	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	СӨБ	ЕБС	Соёлын үйлчилг ээ	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ э	Дүн
1	1-р цэцэрлэг	306518.6				306518.6
2	3-р цэцэрлэг	345192.0				345192.0
3	4-р цэцэрлэг	479285.2				479285.2
4	5-р цэцэрлэг	475235.0				475235.0
5	6-р цэцэрлэг	211393.7				211393.7
6	7-р цэцэрлэг	465231.0				465231.0
7	8-р цэцэрлэг	315625.7				315625.7
8	10-р цэцэрлэг	485012.5				485012.5
9	11-р цэцэрлэг	206457.5				206457.5
10	12-р цэцэрлэг	532607.8				532607.8
11	13-р цэцэрлэг	585011.6				585011.6
12	15-р цэцэрлэг	514317.4				514317.4
13	18-р цэцэрлэг	521211.8				521211.8
14	21-р цэцэрлэг	493828.8				493828.8
15	22-р цэцэрлэг	480629.2				480629.2
16	23-р цэцэрлэг	443372.5				443372.5
17	24-р цэцэрлэг	175099.3				175099.3
18	25-р цэцэрлэг	57721.7				57721.7
19	Хувийн цэцэрлэгүүд	856028,3				856028,3
37	1-р сургууль		1040401,9			1040401,9
38	4-р сургууль		1177317,8			1177317,8
39	Од цогцолбор		2081728,9			2081728,9

## МЭДЭЭЛЭЛ

4					
0	ОИЦогцолбор		3126344,0		3126344,0
4					
1	9-р сургууль		1247114,3		1247114,3
4					
2	12-р сургууль		562295,6		562295,6
4					
3	15-р сургууль		1458076,1		1458076,1
4					
4	Жигүүр цогцолбор		1214215,0		1214215,0
4					
5	18-р сургууль		1169130,2		1169130,2
4					
6	ХААИС-ийн лицей		51681,3		51681,3
4					
7	ТИС-ийн лецей		35600,3		35600,3
4					
8	30-р сургууль		137173,9		137173,9
4					
9	НТБТөв		299681,5		299681,5
5					
0	Хувийн сургуулиуд		650547,0		650547,0
5					
1	ЕБС багц		119557,7		119557,7
6					
0	Музей			72995,1	72995,1
6					
1	Номын сан			139456,6	139456,6
6					
2	Хүүхдийн номын ордон			163455,0	163455,0
6					
3	ГОС ХОТ ӨЭМТөв			444884,9	444884,9
6					
4	Түвшин холбоо ӨЭМТөв			168532,0	168532,0
6					
5	Амин холбоо ӨЭМТөв			141645,4	141645,4
6					
6	Медстоб ӨЭМТөв			216561,1	216561,1
6					
7	Гэрэлтэй ӨЭМТөв			125103,1	125103,1
<b>НИЙТ ДҮН</b>		<b>7949779,6</b>	<b>14370865,5</b>	<b>375906,7</b>	<b>1096726,5</b>
				<b>23793278,3</b>	

**Долоо.** Сумын 2017 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай:

1. Сумын татварын болон татварын бус орлого **2126619,3** мянган төгрөг;
2. Сумын төсөвт аймгийн төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг **23793278,3** мянган төгрөг.

**Найм.** Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

## МЭДЭЭЛЭЛ

---

**Ес.** Орон нутгийн хөгжлийн сангаар 2017 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

**Арав.** Энэ тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА Ж.БАЛЖИННЯМ

## МЭДЭЭЛЭЛ

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн  
ээлжит 2 дугаар хуралдааны 02/06 дугаар  
тогтоолын нэгдүгээр хавсралт

### Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт

Д/д	Төсвийн эрх захирагч нар, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр		Зорилтот түвшин		Зарцуулах төсөв /мян.төг/
			Чанар	Тоо	
1.	Иргэдийн хурлын дарга				124852,5
1.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа				124852,5
	1.1.1.	ИТХ-ын ажлын алба	МУ-ын ЗЗНДНТУТХ, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйл ИТХ-ын чиг үүргийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх;	ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 8-оос доошгүй, ИТХ-ын хуралдаан 2-оос доошгүй удаа хуралдах	124852,5
2.	Засаг дарга				25217486,0
	2.1.	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага			1,030,135.3
	2.1.1.	ЗДТГазар, Багийн Засаг дарга нар	Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг үзүүлэх хууль тогтоомжид нийцсэн байх;	Шуурхай, хүртээмжтэй 76428 иргэн.	979181,6
	2.1.2.	Орон нутгийн нөөц хөрөнгө	МУ-ын ЗЗНДНТУТХ, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар	Түргэн шуурхай	48500,0

## МЭДЭЭЛЭЛ

			батлагдсан "Орон нутгийн нөөц хөрөнгийн тухай журам" хууль тогтоомжид нийцсэн байх;		
<b>2.2.</b>	<b>Тусгай зориулалтын сан</b>				<b>396526,1</b>
	2.2.1.	Сум хөгжүүлэх сан	Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйл, ЗГ- ын 2016 оны 153- р тогтоол, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох;	32 иргэн, 13 ААНБ-д зээл олгох, шинээр бий болгох ажлын байрны тоо 112-с доошгүй	396526,1
<b>2.2.</b>	<b>Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ</b>				<b>23793278,3</b>
	2.2.1.	Сургуули йн өмнөх боловсро л	Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, ЗГ-ын 2012 оны 94-р тогтоол;	36 цэцэрлэг/төри йн 17,хувийн 19/ ажиллагсдын тоо 732 Хамрагдах хүүхдийн тоо 5943 буюу 91.8%	7949779,6
	2.2.2.	Ерөнхий боловсро л	Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, ЗГ-ын 2012 оны 94, 106 дугаар тогтоол;	23 сургууль /төрийн 13,хувийн 10/ Ажиллагсдын тоо 1519 Хамрагдах хүүхдийн тоо- 15485 Дотуур байранд хамрагдах хүүхдийн тоо- 215 Үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо- 7685	14370865,5

## МЭДЭЭЛЭЛ

	2.2.3.	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.4;	5 байгууллага ажиллагсдын тоо- 118 Шуурхай хүртээмжтэй- 76428 хүн ам	1096726,5
	2.2.4.	Соёлын үйлчилгээ	Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.3;	3 байгууллага ажиллагсдын тоо-40, Үйлчлүүлэгчдийн тоо-58500	375906,7

---oOo---

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн  
ээлжит 2 дугаар хуралдааны 02/06 дугаар  
тогтоолын хоёрдугаар хавсралт

**Орон нутгийн хөгжлийн сангаар 2017 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл,  
арга хэмжээний жагсаалт**

(мян.төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	СИТХ-аар 2016.12.12		
		Эхлэх дуусах хугацаа	Нийт төсөвт өртөг	Санхүүжүүлэх дүн
1.0	<b>Засаг дарга</b>		<b>68,300,0</b>	<b>68,300,0</b>
1.1	<b>Хөрөнгө оруулалт</b>		<b>68,300,0</b>	<b>68,300,0</b>
<b>Шинээр эхлэх хөрөнгө оруулалт</b>			<b>68,300,0</b>	<b>68,300,0</b>
1.1.2.1	Төсөл хөтөлбөр /ЗДҮАХ хэрэгжүүлэх зорилтын хүрээнд/	2017	63,300,0	63,300,0
1.1.2.2	Үндэсний их баяр наадмын зардал /Дархан сум/	2017	5,000,0	5,000,0

---oOo---




## ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН

Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчийн хуралдаан 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хуралдаж, нийт 6 асуудлыг авч хэлэлцэв. Үүнд:



1. Дархан сумын ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн хоёрдугаар хуралдааны товыг зарлах тухай
2. Дархан сумын ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн хоёрдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг батлах тухай
3. Дархан сумын ИТХ, Тэргүүлэгчдийн 2017-2020 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай
4. ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны дэгийг батлах тухай
5. Дархан сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай
6. Төрийн дээд шагналд уламжлах тухай



Хуралдаан хэлэлцсэн асуудлуудаараа тогтоол гаргав.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН  
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 57

Дархан

Сумын ГХУСА33-ийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь заалтуудыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ НЬ:

Нэг. Дархан сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Дарга:	Ж.Балжинням - Сумын ИТХ-ын дарга
Орлогч дарга:	Б.Азжаргал - Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Баттулга - Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн хошууч
Гишүүдэд:	Б.Ганхүү – Онцгой байдлын газрын орлогч дарга Д.Баярмаа – Сум дундын шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн М.Гансүх – Эрүүл мэндийн газрын Сэтгэцийн кабинатын эмч Ч.Эрдэнэбилэг – Боловсрол соёл, урлагийн газрын нийгмийн ажилтнууд хариуцсан мэргэжилтэн Д.Тулга – Дархан сумын ЗДТГ-ын дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Норовсамбуу – Монголын Радио МОНЦАМЭ –ийн Дархан дахь сурвалжлагч

ДАРГА

Ж.БАЛЖИННЯМ



D: hural/togtool/

Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит хуралдаан 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдөр хуралдаж, нийт 8 асуудлыг авч хэлэлцэв. Үүнд:



- Байранд дугаар олгох тухай
- Жигүүр цогцолбор сургуулийн 25 жилийн ойг тэмдэглэх тухай
- 2017 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах тоог тогтоох тухай
- ЗДТГ-ын жижүүр Ж.Нямсамбуугийн өргөдлийн тухай
- Төрийн дээд шагналд уламжлах тухай
- Дархан сумын ИТХ, Тэргүүлэгчдийн 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэлийн төслийн тухай
- ИТХ-ын дэргэдэх Хороодын бүрэлдэхүүн, ажиллах журмын төслийн тухай
- ИТХ-ын 2016 онд хийсэн ажлын товч мэдээлэл
- Дархан сумын Засаг даргын 2016 онд хийсэн ажлын тайлан
- Дархан сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн тухай
- Аймгийн Аудитын газраас 2016 оны төсвийн тодотгол, 2017 оны төсвийн төсөлд өгөх саналын тухай
- 2016 оны батлагдсан төсөвд тодотгол хийх
- Сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх зорилт, төсвийн төслийн тухай /СХС, ОНХС/

Хуралдаан хэлэлцсэн асуудлуудаараа тогтоол гаргав.

Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит хуралдаан 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, 2 асуудлыг авч хэлэлцэв. Үүнд:



- Байранд дугаар олгох тухай
- Төрийн дээд шагналд уламжлах тухай

Хуралдаан хэлэлцсэн асуудлуудаараа тогтоол гаргав.

### АЖЛЫН ХЭСЭГ ЗӨВЛӨЛДЛӨӨ

Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчид 2016 оны 11 сарын 15-ны өдөр анхдугаар зөвлөгөөнөө хийж, Төсөл боловсруулах ажлын хэсэг болон Хурлын ажлын албанаас боловсруулсан Дархан сумын ИТХ, Тэргүүлэгчдийн 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэлийн төсөл, Дархан сумын ИТХ-ын дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, ажиллах журмын төслийг хэлэлцүүлж, Төлөөлөгчдийн саналыг авах ажлыг зохион байгуулав.

Дээрх төслүүдийг Төсөл боловсруулах ажлын хэсэг “Дархан 2022” хөгжлийн хөтөлбөр, Дархан-Уул аймгийн ИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд баримталж ажиллах үндсэн чиглэл, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Дархан сумын өмнөх бүрэн эрхийн хугацаанд баримталж ажилласан үндсэн чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг судалж, боловсруулсан байна.

Төлөөлөгчид хэлэлцүүлж буй бодлогын баримт бичгийн төслүүдийг амьдралд хэрэгжих боломжтой, иргэдийн эрх ашиг, орон нутгийн хөгжилд ач тусаа өгөх асуудлуудыг тусгах талаар санал бодлоо илэрхийлж зөвлөлдлөө.



Зөвлөлгөөнөөр Дархан сумын ИТХ, Тэргүүлэгчдийн 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэлийн төслийг нарийвчлан хэлэлцэж, Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулахаар тогтлоо.

### ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЗӨВЛӨЛГӨӨН БОЛОВ

Төлөөлөгчдийн зөвлөлгөөн 11 дүгээр сарын 24-ны өдөр Дархан сумын хуралдааны танхимд болов. Зөвлөлгөөнд үндсэн 4 асуудлаар мэдээлэл хийлээ. Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчид Дархан сумын хөгжлийн хөтөлбөр /2012-2022/, Дархан –Уул аймгийн ИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд баримтлах үндсэн чиглэл, Дархан –Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2017-2020/, Дархан сумын ИТХ-ын үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын бичиг баримтуудтай танилцаж, 3-4 удаа хуралдаж, асуудлуудаа төслийн хэмжээнд боловсруулсан. Өнөөдөр ИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны чиглэлийг эцэслэн хэлэлцлээ.



ИТХ-ын дэргэдэх хороодын ажиллах журмын талаар ажлын хэсгийн ахлагч Н.Болор-Эрдэнэ мэдээлэл хийв. Түүнчлэн спортын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг идэвхжүүлэх талаар санал солилцсон байна. Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн зөвлөлгөөний төгсгөлд ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Болдбаатар:-

“ХАСХОМ”-ийн талаар сургалт явуулж хуулийн хугацаанд буюу 12 дугаар сарын 5-ны өдрийн дотор мэдүүлэхийг зөвлөлөө.

### ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СУМДЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчид 12 дугаар сарын 8, 9-ний өдөр ИТХ-ын Төлөөлөгчдөд зориулсан үндэсний суурь сургалтанд хамрагдав. УИХ-ын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулжээ.



Энэхүү сургалтаар Хурлын Төлөөлөгчид “Орон нутгийн төсөв санхүүгийн удирдлага”, “Иргэдийн оролцоо, иргэдтэй харилцах нь”, “Байгаль хамгаалал газрын харилцаа”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын Үндсэн хуулийн ба эрх зүйн үндэс, хуралдаан, хуралдааны дэг” зэрэг сэдвүүдээр мэдлэг эзэмшив. Энэ сургалт Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн хувьд ээлжит 2 дугаар хуралдааны өмнө зохион байгуулагдсанаараа үр дүнтэй сургалт болсон юм.



### АТГ-ААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БАГИЙН ИНХ-ЫН ДАРГА НАР ОРОЛЦОВ

Авилгатай тэмцэх газрын ажлын хэсэг Дархан-Уул аймагт 2016 оны 11 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд ажиллав. Ажлын хэсэг төрийн бус байгууллага, Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нарын төлөөллийг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийн үеэр авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр, олон нийтийн хяналтын дэд зөвлөлийн талаар танилцуулж мэдээлэл хийсэн юм. Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нар Авлигатай тэмцэх газраас авилгын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, Авлигаас урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл дутмаг байгааг хөндөн яриу.



### ДАРХАН СУМЫН БАГИЙН ИНХ-ЫН ДАРГА НАРЫН ЗӨВЛӨГӨӨН БОЛОВ

Дархан сумын Багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарын зөвлөгөөн 2016.11.17-ны өдөр аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд боллоо. Тус зөвлөгөөнөөр үндсэн 4 асуудлаар мэдээлэл хийв. Зөвлөгөөний эхэнд Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням: Шинээр сонгогдсон ИТХ-ын Төлөөлөгчдийн товч танилцуулга, цаашид баримтлан ажиллах зарчмын талаар ярилаа. 2017-2020 оны ИТХ-ын Төлөөлөгчид харьцангуй залуужсан. Төлөөлөгчдийг сургаж, дадлагажуулах, иргэд сонгогчидтой уулзах, байнгын холбоотой ажиллуулахад ИТХурал, Багийн ИНХ-ын дарга Тэргүүлэгчид дэмжин тусалж ажиллах, туршлагатай Багийн ИНХ-ын дарга нар Төлөөлөгч бүрийг иргэд сонгогч, ард иргэдтэй холбох ажлыг зохион байгуулах, тухайн багт тулгамдсан асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг хийхэд анхаарч ажиллахыг хүслээ. Зөвлөгөөнөөр 2016 онд сонгогдсон ИТХ-ын Төлөөлөгчид, Хороодын ажиллах журам, бүрэлдхүүнийг танилцуулав. Түүнчлэн Багийн ИНХ-ыг ямар хэлбэрээр хийх талаар санал авлаа. Зөвлөгөөний төгсгөлд Дархан сумын ИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд баримталж ажиллах үндсэн чиглэл, Сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж 2016.12.02 ны өдрийн дотор нэгтгэж ирүүлэхийг үүрэг болголоо.



### АЙМАГ, СУМДЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН “ДАРХАН МИНИЙ ХОТ-2016” СПОРТЫН АНХДУГААР НААДАМД “ДАРХАН СУМ” –ЫН ИТХ ТЭРГҮҮЛЛЭЭ

Дархан-Уул аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхим, Биеийн тамир, Спортын газар хамтарч аймаг, сумдын ИТХ-ын Төлөөлөгчдийн дунд зохион байгуулсан “Дархан-Миний хот 2016” спортын анхдугаар наадам 2016.11.27-ны өдөр Спортын ордонд боллоо.

Дархан-Уул аймгийн ИТХ 139 төлөөлөгчтэй тэдгээрээс аймгийн ИТХ, дөрвөн сумын ИТХ тус бүр нэг баг бүрдүүлж анхдугаар наадамд идэвхтэй оролцож, гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис, шатар, даам, биллиард зэрэг спортын зургаан төрлөөр өрсөлдөж хурд хүч, авьяас чадвараа сорилоо.



Анхдугаар наадмыг аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат нээж хэлэхдээ:

“Ард түмнийхээ итгэлийг хүлээж сонгогдон ажиллаж буй аймаг, сумдын ИТХ-ын Төлөөлөгчдийн хамтын ажиллагаа, нэгдмэл байдлаас орон нутгийн цаашдын хөгжил дэвшил шууд хамаарна. Энэхүү спортын нөхөрсөг тэмцээн нь аймгийн нийт иргэдийн төлөөлөгчид бие биетэйгээ танилцаж цаашид нэг баг хамт олон болж ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилготой юм” хэмээн онцлов. Мөн аймгийн Засаг дарга С.Насанбат “Аймаг, сумдын ИТХ-ын Төлөөлөгчдийн дунд спортын бага наадмыг



уламжлал хэлбэрээр тогтмол зохион байгуулах болно” гээд нийт тамирчин төлөөлөгчдөд баяр хүргэж амжилт хүслээ.

Тэмцээний дүн гарахад багийн нийлбэр дүнгээр Ж.Балжинням ахлагчтай Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн баг тэргүүн байрт шалгарч цомын эзэн боллоо.



### ДАРХАН СУМЫН ГХУСАЗЗ-ИЙН ХУРАЛДААН БОЛОВ

Дархан сумын ГХУСАЗЗ-ийн хуралдаан 2017.01.10-ны өдөр болов. Хуралдаанаар 2016 онд Дархан сумын хэмжээнд зохион байгуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тайлан, мэдээллийг сонслоо. Зөвлөлийн гишүүд тайлан мэдээлэлтэй холбогдуулан асуулт тавьж, хариулт авч, 2017 онд Дархан сумын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд тусгах ажил хэрэгч олон саналууд гаргалаа. Харин өнөөдөр хуралдааны шийдвэрийн дагуу Дархан сумын Засаг дарга Б.Азжаргалд ГХУСАЗЗ-ийн анхны зөвлөмжийг хуралдааны тэмдэглэлийн хамт хүргүүллээ. Энэхүү зөвлөмжид дараах асуудлуудыг тусгалаа. Үүнд:



1. Багийн Засаг дарга нартай байгуулах Үр дүнгийн гэрээний тусгай захиалгат бүтээгдэхүүнд “Багийн нутаг дэвсгэрт гэмт хэргийн гаралт, ахуйн хүрээнд архи дан согтуурах явдлыг бууруулах талаар зохион байгуулсан ажил, үр дүн” гэсэн шалгуур үзүүлэлтийг нэмж, хагас бүтэн жилээр тухайн багийн ажлыг дүгнэхдээ үр дүнг тооцдог байх
2. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулах хамтын ажиллагааны гэрээнд иргэдийг гамшгийн болзошгүй осол аюул, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хотын соёл, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэхэд чиглэсэн

нийгмийн реклам, сэрэмжлүүлэг, санамж зэргийг телевиз, богино долгионы радио, зарын сонин гэх мэт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр үнэ төлбөргүй нэвтрүүлж, иргэдэд шуурхай хүргэж ажиллахыг тусгах нь зүйтэй гэж үзлээ.

Мөн 2017 оны төлөвлөгөөнд:

1. Орон сууцны хороололд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар Сууц өмчлөгчдийн холбоодын үүрэг оролцоог нэмэгдүүлэх
2. Бусад аймгуудын туршлагаар “Архигүй хот” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх
3. Хотын камержуулалтын техник хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмолжуулах, хүчин чадлыг сайжруулах, техникийн шинэчлэлийг үе шаттай хийх
4. Замын цагдаагийн тасагтай хамтарч, хотын дотор шөнийн цагт гэрэл шилжүүлэх, ердийн үед дуут дохиог хэрэглэх асуудлыг Замын хөдөлгөөний дүрмийн хэм хэмжээнд мөрдүүлэх талаар тусгай ажиллагаа, аян зохион байгуулах
5. Дэлхийн зөн ОУБ-ын санхүүжилтээр ЕБС-иуд дээр байгуулсан “Өсвөрийн цагдаа”-гийн 4 танхим, “Аврагч” клубын 2 танхим, Мон-13 төслөөр 2 сургуульд суурилуулсан техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, хүүхэд багачуудад анхны зориулалтаар нь үргэлжлүүлэн ашиглуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах
6. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр Хараа голын эрэг дагуух бургасыг хамгаалах, байгалийн ховор ан амьтан, загас, ургамлын зүйлсийн худалдаанд хяналт тавих
7. Хараа голын гүүрний аюулгүй байдлыг хангуулах, эвдрэлийг засварлуулах
8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи иргэдийн эрх, үүргийг сурталчлах, тэдний мэдлэгийг дээшлүүлэх асуудлуудыг тусгаж хэрэгжүүлэхийг зөвлөв.

Зөвлөлийн хуралдаанаар Дархан сумын ГХУСАЗЗ-өөс 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, Зөвлөлийн ажиллах журмын төсөлд гишүүдээс санал авлаа.

Зөвлөлийн 2017 оны ажлын төлөвлөгөөнд ГХУС ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Хөршийн холбоо зэрэг иргэдийн сайн дурын санаачлагын бүлгэм байгуулах, багуудын нутаг дэвсгэрт Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэд, гэрч, хохирогчийг хамгаалах Түр байршуулах байрыг байгуулах, Дархан сумын 4 дүгээр багийн Төмөр замын өртөөний орчимд Цагдаагийн хэсэг байгуулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хурд сааруулагч, гэрлэн дохио, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх, “Сургуулийн цагдаа” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, Цагдаагийн газраас бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ, саатуулах байранд саатуулагдсан иргэдийн судалгааг авч, багийн ИНХ, Засаг даргад хүргэж ажиллах,

иргэд, оюутан сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах сургалтууд зохион байгуулах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

### ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД, АЖЛЫН АЛБАНЫ ХАМТ ОЛОН “МАЛЧДАД ТУСЛАХ АЯН”-Д НЭГДЭВ

Аймгийн ИТХ-ын даргын санаачилсан малчдад туслах аян үргэлжилсээр байна. Уг аянд төрийн болон хувийн хэвшлийн нийт 20 гаруй аж ахуй нэгж байгууллага хандив өргөжээ. Малчдад туслах “1000 төгрөг” аянд Дархан сумын ИТХ-ын 31 Төлөөлөгч, ажлын албаны 3 ажилтан нэгдэж, хандив өглөө.





Энэ үеэр аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат : “Эдгээр цугларсан хандивыг 2017 оны 2 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд малчдад хүргэнэ “ гэв. Учир нь өвлийн идэр хүйтнийг дөнгөж давсан малчид хаврын хахирган үетэй золгодог. “Дэм дэмэндээ...” хэмээх Монгол түмний эрхэм сургаалийг санаж, Дархан-Уул аймгийн ард иргэд, ААНБайгууллага, хамт олныг “Малчдад туслах 1000 төгрөгийн аян”-д нэгдэхийг уриалж байв.

### ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ХҮСЭЛТ ИЛГЭЭВ

Дархан сумын ИТХ-ын дарга гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар БНСУ-ын Кёнги аймгийн Бүчон хотын ИТХ-ын дарга Кан, Дун-Гүд хүсэлт тавьж, шинэ жилийн мэндчилгээ хүргүүлээ.

Уг мэндчилгээнд: Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХурал 2015 оны 7 дугаар сард үзэглэсэн хоёр талын найрамдалт харилцааны “Санамж бичиг”-ийг үндэслэн хоёр талын хамтын ажиллагааг цаашид үргэлжүүлэн, улам өргөжүүлэн хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлж байна.

Өнгөрсөн хугацаанд хоёр талын Хурлын Төлөөлөгчид харилцан айлчилсан, Бүчон хотын Хурлын Төлөөлөгчдийн чин сэтгэлийн тусламж дэмжлэгээр манай сумын хөгжлийн бэрхшээлтэй хоёр иргэнд чихний дунгийн суулгацын мэс заслыг үнэ төлбөргүйгээр хийлгэж, тэдэнд амьдралын баяр баясгаланг бэлэглэсэн зэрэг ажил хэрэгжсэнд бид сэтгэл нэн хангалуун байдаг юм.



Дархан сумын ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаан 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр болж, 31 Төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч, Дархан сумын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийг сонгож, Засаг даргад Б.Азжаргалын нэрийг дэвшүүлэн томилуулснаар Дархан сумын шинэ Хурал, Засаг дарга ажилдаа ороод байна. БНСУ-ын Кёнги аймгийн Бүчон хотын ИТХ-ын дарга Кан, Дун-Гү таныг холбогдох төлөөлөгчдийн хамт тааламжтай цагтаа Монгол Улсын Дархан-Уул аймгийн Дархан сумд айлчлан ирэхийг урьж байна. Та бид хамтдаа хоёр хотын ард иргэдийн хооронд найрамдлын гүүр болно гэдэгт итгэлтэй байна хэмээн дурьджээ.

ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН  
АЖЛЫН АЛБА



Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2017 оны ... дугаар сарын ... ны өдрийн  
... тоот тогтоолын ... Дүгээр хавсралт

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ИТХ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС 2017 ОНД ДЭВШҮҮЛСЭН  
ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2017.01.11

Дархан

Нэг . Дархан сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдээс 2017 онд дэвшүүлэх зорилго, зорилт

**Эрхэм зорилго:** Иргэдийн хэрэгцээ шаардлага, тэдний идэвхтэй оролцоонд тулгуурлан, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлэхэд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлнэ.

**Зорилго:** Иргэдийн эрх ашиг, орон нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх, хэрэгжилтийг хангуулах замаар иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулна.

**Зорилт 1.** Дархан сумын ИТХ-ын 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэл, Дархан сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих

**Зорилт 2.** Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийг чадавхижуулах сургалт, зөвлөлгөөнд тогтмол хамруулах, цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, гадаад орны болон бусад аймгуудын туршлагаас суралцах

**Зорилт 3.** Багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчдийн ажиллах нөхцөлийг сайжруулах, тэдний бүтээлч санал санаачлагыг дэмжин, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх

**Зорилт 4.** Хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх

А. Төсвийн болон Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнөөр хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэлд хяналт тавих

Б. Нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд хяналт тавих

**Зорилт 5.** Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

**Зорилт 6.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлыг хангаж, хуулийн хүрээнд зохион байгуулах

**Зорилт 7.** Сумын ИТХ-ын ажлын албаны үйл ажиллагааг чадавхижуулах

**Зорилт 8.** Цахим мэдээллийн сүлжээг өргөжүүлэх, мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх урсгалыг сайжруулах

**Зорилт 9.** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах

**Хоёр.** Дархан сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдээс 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа /улирал/				Хариуцах эзэн	Одоогийн байдал	Хүрэх үр дүн
		I	II	III	IV			
<b>Зорилт 1.</b> Дархан сумын ИТХ-ын 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэл, Дархан сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих								
1.	Дархан сумын ИТХ-ын 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах					Тэргүүлэгчид, ажлын алба		
2.	Тэргүүлэгчдийн хуралдаанаар цаг үеийн болон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хэрэгжилтэнд хяналт тавих					Тэргүүлэгчид, ажлын алба		
3.	Сумын ИТХ-ын Хороодыг шуурхай удирдлагаар хангаж, үйл ажиллагааг идэвхжүүлэх, <b>тогтмолжуулах</b>					Тэргүүлэгчид, ажлын алба	Урьд нь үйл ажиллагаа тогтмолжоогүй	ИТХ-аас гарах шийдвэр бодитой болно.
4.	2017 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай					ИТХ, ажлын алба		Төсвийн тухай хууль хэрэгжилт сайжирна.
5.	Засаг даргын "Үйл ажиллагааны хөтөлбөр" /2017-2020 / оны хэрэгжилтийг хангуулах					Сумын хөгжлийн хороо	Бүрэн эрхийн хугацаа дууссан.	
6.	Засгийн газрын тогтоолын хүрээнд Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг, хөрөнгийг бүрдүүлэх, тайлагнах, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх					Сумын ИТХ ЗДТГазар	ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхийн хугацаа дууссан	Зээлийн зарцуулалт, хяналт сайжирна.
<b>Зорилт 2.</b> Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийг чадавхижуулах сургалт, зөвлөлгөөнд тогтмол хамруулах, цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, гадаад орны болон бусад аймгуудын туршлагаас суралцах								

**Зорилт 9.** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах

**Хоёр.** Дархан сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдээс 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа /улирал/				Хариуцах эзэн	Одоогийн байдал	Хүрэх үр дүн
		I	II	III	IV			
<b>Зорилт 1.</b> Дархан сумын ИТХ-ын 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэл, Дархан сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих								
1.	Дархан сумын ИТХ-ын 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах					Тэргүүлэгчид, ажлын алба		
2.	Тэргүүлэгчдийн хуралдаанаар цаг үеийн болон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хэрэгжилтэнд хяналт тавих					Тэргүүлэгчид, ажлын алба		
3.	Сумын ИТХ-ын Хороодыг шуурхай удирдлагаар хангаж, үйл ажиллагааг идэвхжүүлэх, тогтмолжуулах					Тэргүүлэгчид, ажлын алба	Урьд нь үйл ажиллагаа тогтмолжоогүй	ИТХ-аас гарах шийдвэр бодитой болно.
4.	2017 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай					ИТХ, ажлын алба		Төсвийн тухай хууль хэрэгжилт сайжирна.
5.	Засаг даргын "Үйл ажиллагааны хөтөлбөр" /2017-2020 / оны хэрэгжилтийг хангуулах					Сумын хөгжлийн хороо	Бүрэн эрхийн хугацаа дууссан.	
6.	Засгийн газрын тогтоолын хүрээнд Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг, хөрөнгийг бүрдүүлэх, тайлагнах, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх					Сумын ИТХ ЗДТГазар	ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхийн хугацаа дууссан	Зээлийн зарцуулалт, хяналт сайжирна.
<b>Зорилт 2.</b> Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийг чадавхижуулах сургалт, зөвлөлгөөнд тогтмол хамруулах, цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, гадаад орны болон бусад аймгуудын туршлагаас суралцах								

	шинжилгээ хийх, хяналтын үйл ажиллагааг сайжруулах			ИТХ-ын Хороод	төлөлт сайжирна
2.	Орон нутгийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын хуулийн цаглабарыг мөрдөж иргэдийн саналыг эрэмбэлэн баталгаажуулах			Ажлын алба, Багийн ИНХ ИТХ-ын Хороод	Хууль хэрэгжинэ.
3.	Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд хяналт шалгалт хийх			Ажлын хэсэг Багийн ИНХ ИТХ-ын Хороод	Ажлын чанар сайжирна, иргэдийн оролцоо нэмэгдэнэ.
4.	Сумын төсвийн ил тод байдал, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийх			ИТХ-ын Хороод	Хууль хэрэгжинэ
5	Нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд хяналт тавих			ИТХ-ын Хороод	Иргэдийн сэтгэл ханамжийн баталгааг хангана.
<b>Зорилт 5. Иргэний танхимийн үйл ажиллагааг шинэлэг хэлбэрт шилжүүлэх, иргэний санал, гомдлыг шийдвэрлүүлэх</b>					
1.	Гэр хорооллын иргэдийн тулгамдсан асуудлууд			Иргэний танхим	Гэр хорооллын иргэдийн тулгамдсан асуудлаар өмнө хэлэлцүүлэг хийгдэж байгаагүй
2.	Малчин багийн иргэдэд тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг			Иргэний танхим	Мэдээ мэдээлэл дутмаг, иргэд үүргээ хэрэгжүүлэх идэвхи сул
4.	Засаг даргын тайланг багийн иргэдээр хэлэлцүүлэх,			Ажлын алба ЗДТГазар	Багийн тус бүрт уулзалт хэлэлцүүлэг цөөн хийгдсэн
5.	УИХ-аас шинээр батлагдсан болон өөрчлөгдсөн хууль тогтоомжоор иргэдэд мэдээ мэдээлэл өгөх			Аймаг сумын иргэний танхим	Цаг тухай бүрт аймаг, сумын ИТХ, Иргэний танхимаар дамжуулан танилцуулагдаж байгаа
6.	Сумын ИТХ, иргэдэд үйлчлэх төв болон цахим хэлбэрээр ирсэн гомдол саналын мөрөөр шийдвэрлэж ажиллах			Хууль эрх зүй өргөдөл гомдлын хороо, Хэвлэл мэдээллийн	Иргэдийн хандлага сул байна. Иргэд аргаа мэдэхгүй байна



	Иргэдийн өмнө тулгамдаж асуудлаар холбогдох мэргэжилтний байгууллагуудтай хамтран ажиллах	ажилтан	Төр иргэний холбох харилцаа сул	Иргэдийн өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэнэ.
7.	Иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлаар холбогдох мэргэжилтний байгууллагуудтай хамтран ажиллах	Иргэний танхим Ажлын алба	Төр иргэний холбох харилцаа сул	Иргэдийн өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэнэ.
8	"Үндсэн хууль"-д өөрчлөлт оруулах эсэх асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах	Иргэний танхим Ажлын алба		
<b>Зорилт 6. . Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлыг хангаж, хуулийн хүрээнд зохион байгуулах</b>				
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлыг хангаж, хуулийн хүрээнд батлагдсан цагалбарын дагуу зохион байгуулах, хяналт тавих	Тэргүүлэгчид, ажлын алба		
<b>Зорилт 7. Сумын ИТХ-ын дотоод болон ажлын албаны үйл ажиллагааг чадаажуулах</b>				
1	ИТХ-аас гарах тогтоол, бусад баримт бичгийн стандартыг сайжруулна	Ажлын алба	Бичиг хэргийг стандарт сайжирна.	
2	ИТХ-аас гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнах	Ажлын алба	Нэг удаа хэлэлцэж байсан	Хагас бүтэн жилээр тайлагнана.
3	Сумын ИТХ-ын ажлын албанд болон багуудын ИНХ-аас гарсан гомдол саналуудыг шийдвэрлүүлэн, хариуг иргэн бүрт хүргэх	Ажлын алба, Хууль эрх зүй өргөдөл гомдлын хороо	Иргэн бүртэй тулж ажиллах нь дутагдалтай	Иргэдийн идэвх сайжирна.
4	2017 онд "Алдарт эх"-ийн 1, 2 дугаар одонгоор шагнагдах ээжүүдийн материалыг хүлээн авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд уламжлах	Ажлын алба, сумын ЗДТГ	Ээжүүдийг бүрэн хамруулах	
5	Төлөөлөгчдийн хувийн хэргийг бүрдүүлэх, цахим хаягтай болгох	Ажлын алба, Хороодын дарга нар	Цахим хаяггүйтул зардал их байсан	Харилцаа холбоо сайжирна.
6	Сумын ИТХ-ын хуралдааны бэлтгэлийг хангах	Тэргүүлэгчид, ажлын алба		
7	Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэлийг хангах	Ажлын алба		
8	Улирал бүр төлөвлөгөө гарган, биелэлтийг хангах	Ажлын алба		
9	Дархан сумын ИТХ-ын 2016 оны	Ажлын алба	Санхүүгийн жилийн тайланг	Холбогдох байгууллагаар

санхүүгийн жилийн тайланг бэлтгэн хүргүүлэх				хугацаанд нь шалгуулж хэвшсэн	бодит үнэлэлт өгөгдөнө	дүгнэлт
10	Шилэн дансны хуулийн хэрэгжилт, санхүүгийн ил тод байдлыг хангах, санхүүгийн баримт, холбогдох бичиг баримтын стандартыг сайжруулах			Ажлын алба	Санхүүгийн ил тод байдал, сахилага бат, эмх цэгц сайжирна	
<b>Зорилт 8. Цахим мэдээллийн сүлжээг өргөжүүлэх, мэдээ мэдээлэлийг иргэдэд хүргэх урсгалыг сайжруулах</b>						
1.	www.khural.mn, facebook, хаягуудын хөтөлөлтийг сайжруулах, мэдээлэл оруулах, цахим сан бий болгох			Ажлын алба	Өдөр тутам хийгдэж байгаа	Мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ
2.	Төвийн болон орон нутгийн телевизүүдэд Сумын ИТХ, Төлөөлөгчдийн болон багийн ИНХ-ын үйл ажиллагааг сурталчлах, мэдээ, мэдээлэл өгөх			Ажлын алба	Орон нутгийн телевизүүдэд мэдээлэл өгөх сурталчлах ажлууд хийгдсэн	Хийсэн ажлууд иргэдэд ил тод хүрнэ
3.	Сумын ИТХ, Төлөөлөгчдийн болон багийн ИНХ-ын үйл ажиллагааг сонин, сэтгүүл, сайтуудад мэдээлэл байршуулах, төвийн хэвлэлд мэдээлэл өгөх			Хэвлэл мэдээлэл	Нутгийн удирдлага хамтран ажиллахад анхаарах	Мэдээллийг цаг алдахгүй, хоцрогдолгүй авна
<b>Зорилт 9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах</b>						
1	<b>Зорилго.</b> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог сайжруулах, тэдний хамтын ажиллагааг уялдуулан зохицуулахад оршино.					
2	<b>Зорилт 1.</b> Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулах					
	<b>Зорилт 2.</b> Төр, төрийн өмчит, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах					
	<b>Зорилт 3.</b> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, мэдээ мэдээлэлээр хангах зорилтуудын хүрээнд 26 үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.					

Жич: ГХУСА33-ийн 2017 оны төлөвлөгөө нь сумын ИТХ-ын 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний салшгүй хэсэг байна.

ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН  
АЖЛЫН АЛБА



Дархан сумын ГХУСАЗЗ-ийн 2017 оны 01 дугаар сарын 10...-ны өдрийн хуралдаанаар батлав.

**ДАРХАН СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗОРИЛГО ЗОРИЛТ**

**Зорилго.** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог сайжруулах, тэдний хамтын ажиллагааг уялдуулан зохицуулахад оршино.

**Зорилт 1.** Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулах

**Зорилт 2.** Төр, төрийн өмчит, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах

**Зорилт 3.** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, мэдээ мэдээллээр хангах

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн	Хамтран зохион байгууллага	Хүрэх үр дүн	Төсөв
<b>Зорилт 1. Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулах</b>						
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өөрсдийн болон бусдын аюулгүй байдлыг хангах ухамсар хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Хөршийн холбоо" байгуулан ажиллуулна. / Иргэдийн сайн дурын санаачлагын бүлгэм /	Жилдээ	ЦГ-ын ХХХТ-ийн дарга	Сумын ИТХ, Сумын ЗДТГ, Иргэн, ААНБ-ууд	Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлнэ	
2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр баг тус бүрт "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэн мэргэжлийн чиг үүргээр хангах, чадавхижуулах	2 улиралд	Хамтарсан багууд	Дархан сумын ЗДТГ	Сайн дурын оролцоо сайжирна	
3	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэд, гэрч хохирогчийг хамгаалах "Тур байршуулах" байрыг байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулах	Жилдээ	ЦГ-ын ХХХТ-ийн дарга	Дархан сум ИТХ, Дархан сум ЗДТГ	Хуулийн хэрэгжилт сайжирч, хүний эрхийн зөрчил гарахгүй	

4	Гар дээрээс согтууруулах ундаа, утаат тамхи худалдан борлуулах зөрчил байнга гардаг Дархан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт төмөр замын ертөөний орчимд "Цагдаагийн хэсэг" байгуулах	Жилдээ	ЦГ-ын ХХХТ-ийн дарга, Дархан сумын Засаг дарга	Аймаг, сумын ИТХ	Хуулийн хэрэгжилт хангагдана
5	Малын хулгайг бууруулах чиглэлээр иргэд, ТББ-уудын санал санаачлагыг дэмжин ажиллах	Жилдээ	ЦГ-ын Малын хулгайтай тэмцэх тасаг	Малчдын бүлэг, ТББ-ууд	Малын хулгайг бууруулна
6	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр Хараа голын эрэг дагуу бургасыг хамгаалах, байгалийн ховор ан амьтан, загас ургамлын зүйлсийн худалдаанд хяналт тавих	Жилдээ	Байгаль орчны газар, Цагдаагийн газар	Иргэний нийгмийн зөвлөл, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажиллах ТББ-ууд	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг буурна
7	Гал түймрийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд аймгийн Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах	Жилдээ	Онцгой байдлын газар	Цагдаагийн газар, Прокурорын газар	Гал түймрийн гэмт хэргийн гаралтыг таслан зогсоох
8	Гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй "Хар цэг"-ийг тодорхойлох	2 улирал	Цагдаагийн газар	Хэсгийн байцаагч, Багийн Засаг дарга	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлнэ
9	Объект, субъектын судалгаанд баяжилт хийх зорилгоор "Google earth" газрын зураг дээр ажиллах программ суулгах	Жилдээ	Цагдаагийн газар	Цагдаагийн газар, Дархан сумын ЗДТГазар	Газрын зураг ашиглан болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлнэ
<b>Зорилт 2. Төр, төрийн өмчит, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах</b>					
1	Багийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээний тусгай захиалгат бүрэлдхүүнд "Багийн нутаг дэвсгэрт гэмт хэргийн гаралт, ахуйн хүрээнд архидан согтуурах явдлыг бууруулах талаар зохион байгуулсан ажил, үр дүн" гэсэн үзүүлэлтийг тусгаж, үр дүнг тооцдог байх	4 улиралд	Дархан сумын Засаг даргын тамгийн газар	Багийн Засаг дарга нар	Тухайн багт гэмт хэргийн гаралт буурна

4	Гар дээрээс согтууруулах ундаа, угаат тамхи худалдан борлуулах зөрчил байнга гардаг Дархан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт төмөр замын өртөөний орчимд "Цагдаагийн хэсэг" байгуулах	Жилдээ	ЦГ-ын ХХХТ-ийн дарга, Дархан сумын Засаг дарга	Аймаг, сумын ИТХ	Хуулийн хэрэгжилт хангагдана	
5	Малын хулгайг бууруулах чиглэлээр иргэд, ТББ-уудын санал санаачлагыг дэмжин ажиллах	Жилдээ	ЦГ-ын Малын хулгайтай тэмцэх тасаг	Малчдын бүлэг, ТББ-ууд	Малын хулгайг бууруулна	
6	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр Хараа голын эрэг дагуу бургасыг хамгаалах, байгалийн ховор ан амьтан, загас ургамлын зүйлсийн худалдаанд хяналт тавих	Жилдээ	Байгаль орчны газар, Цагдаагийн газар	Иргэний нийгмийн зөвлөл, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажиллах ТББ-ууд	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг буурна	
7	Гал түймрийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд аймгийн Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах	Жилдээ	Онцгой байдлын газар	Цагдаагийн газар, Прокурорын газар	Гал түймрийн гэмт хэргийн гараллыг таслан зогсоох	
8	Гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй "Хар цэг"-ийг тодорхойлох	2 улирал	Цагдаагийн газар	Хэргийн байцаагч, Багийн Засаг дарга	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлнэ	
9	Объект, субъектын судалгаанд баяжилт хийх зорилгоор "Google earth" газрын зураг дээр ажиллах программ суулгах	Жилдээ	Цагдаагийн газар	Цагдаагийн газар, Дархан сумын ЗДТГазар	Газрын зураг ашиглан болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлнэ	Дархан сумын 18 хэргийн байцаагч нарыг зөвөрийн компьютерээр хангах
<b>Зорилт 2. Төр, төрийн өмчлөх, хувийн хэвшил, Төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах</b>						
1	Багийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээний тусгай захиалгат бүрэлдхүүнд "Багийн нутаг дэвсгэрт гэмт хэргийн гаралт, ахуйн хүрээнд архидаг согтуурах явдлыг бууруулах талаар зохион байгуулсан ажил, үр дүн" гэсэн үзүүлэлтийг тусгаж, үр дүнг тооцдог байх	4 улиралд	Дархан сумын Засаг даргын тамгийн газар	Багийн Засаг дарга нар	Тухайн багт гэмт хэргийн гаралт буурна	

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын гэрээнд иргэдийг цаг үеийн болзошгүй осол, аюулаас сэргийлэх зэрэг нийгмийн чанартай реклам, сэрэмжлүүлэг, шторк, санамж зэргийг үнэ төлбөргүй нэвтрүүлэх, иргэдэд хүргэх	Жилдээ	Дархан сумын ЗДТГ-ын хэвлэлийн ажилтнууд	Орон нутгийн телевизүүд	Иргэдэд мэдээлэл хүрснээр болзошгүй эрсдлээс сэргийлнэ	
<b>Зорилт 3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, мэдээ мэдээллээр хангах</b>					
10	Хорихоос суллагдсан иргэдийг нийгэмшүүлэх, сургалтанд хамруулах мэргэжил олгох, ажлын байраар хангах	Жилдээ	Цагдаагийн газар, Прокурорын газар	Сумын ЗДТГазар, Багийн Засаг дарга, ТББ-ууд	Иргэдийг нийгэмшүүлж ажилтай болгосноор дахин гэмт хэрэгт холбогдохоос сэргийлнэ
2	Тухайн нутаг дэвсгэр дэх ААНБ-уудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан алба хаагчдыг чадавхижуулах сургалтанд хамруулах	Жилдээ	БСГазар, Цагдаагийн газар	БСГ-ын газар, Сургуулиудын нийгмийн ажилтан	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгоно
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна. /Их дээд, ЕБС, МСҮТ-ийн оюутнууд/	3 улиралд	БСГазар, Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч	БСГ-ын газар, Сургуулиудын нийгмийн ажилтан	Гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж, тэдний хууль эрх зүйн мэдлэг дээшилнэ.
4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, шторк, сэрэмжлүүлэг бэлтгэн, байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх	Жилдээ	Хэвлэл мэдээллийн байгууллагууд	Сумын ИТХ, ЗДТГ	Иргэдэд үнэн зөв мэдээлэл хүрч сэрэмжлүүлэг болно.
6	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах	Жилдээ	ОБГазар	Дархан сумын ЗДТГ, Багийн Засаг дарга	Улиралын чанартай аюулт үзэгдэл ослын

							нар	тоо, хохирол буурна
7	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд сэтгэл заслын сургалт явуулах	Жилдээ	Цагдаагийн газар, ЭМГ азар, нар	Дархан сумын ЗДТГ, Багийн Засаг дарга нар	Сэтгэл гутрал, өвчин эмгэгээс ангижрана			
<b>Дотоод ажлын хүрээнд</b>								
1	ГХУСААЗ-ийн хурлыг зохион байгуулах	Сар бүр	ГХУСАЗЗ-ийн гишүүд	Дархан сумын ИТХ	Үр дүн ирц сайжирна			
2	Зорилтуудын хүрээнд хийгдэх ажлуудын тусгайлсан төлөвлөгөөг гаргуулах, хэрэгжилтэнд хяналт тавих	Улирал бүр	ГХУСАЗЗ-ийн гишүүд	Дархан сумын ИТХ	Дотоод ажил сайжирна			
3	Зөвлөлийн хурлаас батлагдсан ажлын хэсгүүд болон хамтарсан баг, олон нийтийн цагдаа нарын хэрэгжүүлсэн ажлын тайлан сонстол мэдээллийг сонсож үнэлэлт дүгнэлт өгөх	Жилдээ	ГХУСАЗЗ-ийн гишүүд	Зөвлөлийн хурлаас батлагдсан ажлын хэсгүүд болон хамтарсан баг, олон нийтийн цагдаа нар	Дотоод ажил сайжирна			

Дархан сумын ГХУСАЗЗ сар бүр 1 удаа хуралдана. Тус хурлаар цаг үеийн асуудлууд болон тайлан сонстол мэдээллийг сонсож, үнэлэлт дүгнэлт өгнө .

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ :**

1. Насанд хүрээгүй иргэдээс үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл цаашид авах арга хэмжээ  
/ Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч /
2. Дархан сумын 1-16 баг, Өргөө, Малчин багуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийгдэж буй ажлын тайлан мэдээлэл  
/ Сар бүр 1-2 багийн тайлан, мэдээ сонстол хийнэ /
3. Дархан сумын хэмжээнд гал түймрийн нөхцөл байдал цаашид авах арга хэмжээ  
/ Б.Ганхүү ОБГ-ын орлогч дарга /
4. ЕБС-ийн Ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх , талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ  
/ Аймгийн Боловсрол Соёл Урлагийн газар /

5. Дархан сумын хэмжээнд үйлдэгдсэн хулгайн гэмт хэргийн нөхцөл байдал цаашид авах арга хэмжээ / Аймгийн Цагдаагийн газар /
6. Томоохон үйлдвэр аж ахуй нэгжийн ГХУСА33-ийн үйл ажиллагааны тайлан мэдээлэл, сонстол хийх / Дархан Дулааны сүлжээ , Цахилгаан станц, Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ /
7. Дархан сумын хэмжээнд "Хөршийн холбоо " нэвтрүүлсэн багийн тайлан мэдээлэл / Дархан сумын 13 дугаар баг /
8. Хамтарсан багуудын тайлан мэдээлэл , тулгамдсан асуудал / Дархан сумын багууд /

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:



Г. МӨНХГЭРЭЛ